



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2017 оны 4 дүгээр сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 4 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 36.5%-иар буюу 807.2 сая ам.доллараар өсч 3017.3 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 41%-иар буюу 552 сая ам.доллараар, импорт 29.6%-иар буюу 254.9 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 781.9 сая ам.доллараар давснаар гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 297.3 сая ам.доллараар өссөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 4 сар			Өөрчлөлт			
	2014	2015	2016	2015/2014		2016/2015		2015	2016	2017	2016/2015		2017/2016	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	11,011	8,467	8,274	(2,544)	-23.1%	(192)	-2.3%	2,487	2,210	3,017	(276)	-11.1%	807.2	36.5%
Экспорт	5,774	4,669	4,916	(1,105)	-19.1%	247	5.3%	1,452	1,347	1,899.6	(105)	-7.2%	552.3	41%
Импорт	5,237	3,798	3,358	(1,439)	-27.5%	(439)	-11.6%	1,034	863	1,117.7	(172)	-16.6%	254.9	29.6%
Тэнцэл	538	872	1,558	334		686	78.7%	418	485	782	67	15.9%	297.3	61.4%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2017 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 804.1 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 307 сая ам.доллараар өссөн байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /4 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 69.3% буюу 2091.1 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 11.1% буюу 335 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 51.6%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 46.5%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /4 сарын гулсах дундаж/



Хүснэгт 2. Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

Үнийн индексийн төрөл*	2016.04 сар	2017.03 сар	2017.04 сар	Жил Δ	Сар Δ
Экспорт	0,74	0,96	1,06	44%	11%
Зэсийн баяжмал	0,35	0,37	0,40	15%	6%
Чулуун нүүрс	0,41	0,64	0,69	68%	8%
Ямааны угаасан ноолуур	0,34	0,40	0,44	29%	8%
Импорт	0,56	0,59	0,59	6%	1%
Хэрэглээний бараа	0,77	0,78	0,77	0%	-2%
Хөрөнгө оруулалтын бараа	0,51	0,51	0,52	4%	4%
Нефтийн бүтээгдэхүүн	0,43	0,53	0,54	25%	1%
Худалдааны нөхцөл	1,32	1,64	1,80	36%	10%

* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 36%-иар, өмнөх сараас 9.8%-иар тус тус өсөн 1.797 хүрлээ. Тайлант сард хөрөнгө оруулалт, нефтийн импортын үнэ өссөн хэдий ч нүүрс, зэс болон ямааны угаасан ноолуурын экспортын үнэ өссөнөөс голлон шалтгаалж худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирсан байна.

Экспорт 2017 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 41%-иар букуу 552.3 сая ам.доллараар өсөв. Уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт нь нийт экспортыг 39.2 нэгж хувиар, уул уурхайгаас бусад төрлийн экспорт нь нийт экспортыг 1.8 нэгж хувиар өсөхөд нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 2.4 нэгж хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 1.1 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
1. Уул уурхай		1 294	89%		1 179	88%		1 707	90%	(115)	-9%	-8%	528	45%	39,2%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	415	667	46%	558	637	47%	502	524	28%	(30)	-4%	-2%	(114)	-18%	-8%
1.2. Чулуун нүүрс	4 248	194	13%	5 008	155	12%	11 432	766	40%	(39)	-20%	-3%	611	394%	45%
1.3. Боловсруулаагүй нефть	2 518	123	8%	2 876	99	7%	2 430	123	6%	(24)	-20%	-2%	24	24%	2%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	1 500	81	6%	1 380	45	3%	1 742	114	6%	(37)	-45%	-3%	69	155%	5%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	3 362	133	9%	4 304	168	12%	1 889	76	4%	35	26%	2%	(92)	-55%	-7%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	43	53	4%	38	39	3%	38	57	3%	(13)	-25%	-1%	18	45%	1%
1.7. Жонш, лейцит, нефелинт	81	19	1%	74	17	1%	79	18	1%	(2)	-11%	0%	2	9%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	13	1%	2	8	1%	2	11	1%	(5)	-38%	0%	3	41%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	3	0%	0	2	0%	0	1	0%	(0)	-15%	0%	(1)	-58%	0%
1.10. Мөнгө /тонн/	27	7	1%	20	8	1%	0	0	0%	0	0%	0%	(7)	-96%	-1%
1.11. Бусад	6	0	0%	39	1	0%	152	17	1%	1	649%	0%	16	17%	1%
2. Мал аж ахуй		71	5%		74	5%		91	5%	3	4%	0%	17	23%	1,3%
2.1. Амьд мал, малын мах	2	4	0%	2	4	0%	3	6	0%	0	4%	0%	2	53%	0%
2.2. Арьс, шир	132	15	1%	79	14	1%	145	13	1%	(1)	-6%	0%	(2)	-11%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	3	0%	0	2	0%	0	1	0%	(1)	-27%	0%	(1)	-29%	0%
2.4. Ноолуур	2	44	3%	2	48	4%	2	66	3%	4	8%	0%	18	38%	1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	3	5	0%	4	6	0%	3	4	0%	1	12%	0%	(1)	-26%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	1	1	0%	0	136%	0%	0	288%	0%
3. Газар тариалан		20	1%		10	1%		3	0%	(10)	-50%	-1%	(7)	-71%	-0,5%
4. Аж үйлдвэрлэл		67	5%		85	6%		99	5%	18	27%	1%	14	16%	1,0%
4.1. Хүнс	1	11	1%	2	12	1%	9	38	2%	1	11%	0%	26	217%	2%
4.2. Ноолууран эдлэл	0	4	0%	0	2	0%	0	4	0%	(2)	-39%	0%	2	75%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	0	2	0%	0	4	0%	0	3	0%	2	116%	0%	(0)	-11%	0%
4.4. Уул уурхай	11	24	2%	8	22	2%	11	35	2%	(2)	-8%	0%	13	58%	1%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-17%	0%	(0)	-77%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж эд анги	0	24	2%	0	43	3%	0	17	1%	18	75%	1%	(26)	-61%	-2%
4.7. Бусад	82	2	0%	79	1	0%	139	2	0%	(0)	-18%	0%	0	26%	0%
5. Бусад		1	0%		0	0%		0	0%	(1)	-64%	0%	(0)	-25%	0,0%
Нийт дүн		1 452		1 347			1 900			(105)	-7%		552,3	41,0%	


%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2017 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
1. Уул уурхай	290.2	55%	237.9	45%	528.2	45%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(58.3)	51%	(55.3)	49%	(113.6)	-18%
1.2. Чулуун нүүрс	430.7	70%	180.6	30%	611.3	394%
1.3. Боловсруулаагүй нефть	(22.5)	-95%	46.3	195%	23.8	24%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	23.6	34%	45.5	66%	69.1	155%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(96.8)	105%	4.5	-5%	(92.3)	-55%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	0.7	4%	17.1	96%	17.7	45%
1.7. Жонш, лейцит, нефелинт	1.2	72%	0.4	28%	1.6	9%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	0.6	19%	2.6	81%	3.2	41%
1.11. Бусад	12.7	78%	3.5	22%	16.2	0%
2. Мал аж ахуй	15.6	91%	1.5	9%	17.1	23%
2.2. Арьс, шир	5.7	-365%	(7.3)	465%	(1.6)	-11%
2.4. Ноолуур	9.3	51%	8.9	49%	18.2	38%
3. Газар тариалан	(2.7)	39%	(4.2)	61%	(6.9)	-71%
4. Аж үйлдвэрлэл	42.1	303%	(28.2)	-203%	13.9	16%
5. Бусад	(0.0)	35%	(0.1)	65%	(0.1)	-25%
Нийт дүн	345.3	63%	207	37%	552.3	41%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн



2017 оны эхний 4 сарын гүйцэтгэл нь экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 345.3 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 207 сая ам.доллараар өссөн байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт нүүрсний экспортын биет хэмжээ, үнэ өссөнөөс шалтгаалж 528.2 сая ам.доллараар өссөн байна. Харин мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ, тоо хэмжээ хоёулаа нэмэгдсэнээс шалтгаалж 17.1 сая ам.доллараар өссөн байна. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын үнэ буурсан хэдий ч биет хэмжээ нэмэгдсэнээс 13.9 сая ам.доллараар өссөн байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2017 оны 4 дүгээр сард 1,271 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.3%-иар, өнгөрсөн сараас 3.2%-иар тус тус өссөн. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,683, 70.2 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 16.6%-иар, төмрийн хүдэр 15.4%-иар өссөн бол өнгөрсөн сартай харьцуулахад харгалзан 2.4%, 20.2%-иар тус тус буурсан байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 4 дүгээр сард 66.7 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 108.2%-иар өмнөх сараас 1.2%-иар өссөн байна.

Импорт 2017 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 29.6%-иар буюу 254.9 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 13 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 12 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 7 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 3 нэгж хувиар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний жин 6 нэгж хувиар өсчээ.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²	
Хэрэглээний бүтээгдэхүүн		328	32%		307	36%		365	33%		(20)	-6%	-2%	58	19%	7%
Түргэн эдэлгээтэй	233	188	18%	226	172	20%	264	201	18%	(16)	-8%	-2%	29	17%	3%	
Хүнс	111	128	12%	113	117	14%	101	137	12%	(11)	-9%	-1%	20	17%	2%	
Эм, тариа	1	22	2%	1	25	3%	1	28	3%	3	12%	0%	3	12%	0%	
Бусад түргэн эдэлгээтэй бараа	121	37	4%	111	30	3%	162	36	3%	(7)	-20%	-1%	6	21%	1%	
Удаан эдэлгээтэй	56	140	14%	40	135	16%	62	164	15%	(5)	-3%	0%	28	21%	3%	
Гутал, хуягас, цунх	12	14	1%	18	15	2%	20	18	2%	0	2%	0%	3	24%	0%	
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба төвөг	27	33	3%	8	27	3%	25	26	2%	(6)	-17%	-1%	(1)	-5%	0%	
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	76	7%	0	74	9%	0	102	9%	(2)	-2%	0%	28	38%	3%	
Бусад удаан эдэлгээтэй бараа	16	17	2%	14	20	2%	17	18	2%	3	15%	0%	(2)	-11%	0%	
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн		345	33%		278	32%		387	35%		(67)	-19%	-6%	109	39%	13%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	6	198	19%	5	160	19%	7	268	24%	(38)	-19%	-4%	108	67%	12%	
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	32	3%	0	29	3%	0	50	5%	(3)	-9%	0%	22	75%	3%	
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	5	167	16%	5	131	15%	7	217	19%	(35)	-21%	-3%	86	66%	10%	
Барилгын материал	343	111	11%	158	66	8%	105	74	7%	(45)	-40%	-4%	8	12%	1%	
Хөрөнгө оруулалтын бусад бараа	12	35	3%	9	51	6%	13	45	4%	16	47%	2%	(7)	-13%	-1%	
Аж үйлдвэрлэлийн орц		155	15%		163	19%		149	13%		8	5%	1%	(13)	-8%	-2%
Хүнсний орц	22	10	1%	109	26	3%	13	6	1%	15	152%	1%	(20)	-77%	-2%	
Химийн бүтээгдэхүүн	43	29	3%	38	24	3%	47	27	2%	(5)	-17%	0%	3	14%	0%	
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	7	4	0%	5	5	1%	11	7	1%	1	14%	0%	2	32%	0%	
Цахилгаан эрчим хүч	0	42	4%	0	43	5%	0	43	4%	0	1%	0%	1	2%	0%	
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0	0%	1	1	0%	1	0	0%	1	457%	0%	(1)	-77%	0%	
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	252	69	7%	208	64	7%	249	66	6%	(4)	-6%	0%	1	2%	0%	
Нефтийн бүтээгдэхүүн		322	20%		243	13%		363	21%		(91)	-44%	-9%	100	88%	12%
Дизель түнш	169	103	10%	107	44	5%	199	108	10%	(59)	-57%	-6%	64	144%	7%	
АИ-92, АИ-95	119	75	7%	103	47	5%	114	69	6%	(28)	-37%	-3%	22	47%	3%	
А-80 болон бусад	35	27	3%	34	23	3%	50	37	3%	(4)	-16%	0%	14	62%	2%	
Бусад		8	0%		2	0%		35	2%		(1)	0%		1	0%	
Нийт дүн		1 034			863			1 118			(172)	-16,6%		254,9	29,6%	

²% - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2017 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	64.4	112%	(6.7)	-12%	57.8	19%
Түргэн эдэлгээтэй	8.9	30%	20.5	70%	29.4	17%
Удаан эдэлгээтэй	55.5	196%	(27.2)	-96%	28.3	21%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	75.1	69%	34.0	31%	109.2	39%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	88.6	82%	19.2	18%	107.8	67%
Барилгын материал	(8.9)	-111%	16.9	211%	8.0	12%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(4.6)	69%	(2.1)	31%	(6.6)	-13%
Аж үйлдвэрлэлийн орц	(22.0)		8.8		(13.2)	-8%
Нефтийн бүтээгдэхүүн	68.8	69%	31.0	31%	99.8	88%
Дизель түнш	49.7	78%	13.9	22%	63.7	144%
АИ-92, АИ-95	7.0	32%	15.1	68%	22.1	47%
А-80 болон бусад	12.1	86%	2.0	14%	14.0	62%
Бусад	2.3	165%	(0.9)	-65%	1.4	0%
Нийт дүн	188.6	74%	66.3	26%	255	30%

2017 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр импорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 188.6 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 66.3 сая ам.доллараар тус тус өсчээ. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт нь тоо хэмжээ нэмэгдсэнээс голлон шалтгаалан 57.8 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 39%-иар өссөн нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 88%-иар өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2017 оны 4 дүгээр сарын байдлаар тонн тутамд 577.3 ам.долларт хүрч 6 сар дараалан өссөн хандлага үргэжлээгүй байна.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /4 сарын гулсах дундаж/

